



СЕКЮРИТИЗ
ҮЦК

2022.05.16-2022.05.20

ГАДААД ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ



2022.05.23-ны after trading session байдлаар

АНУ	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
US30	31,497.00	0.77%	-2.24%	-7.48%	-8.41%
US500	3,942.36	1.04%	-1.64%	-8.24%	-6.07%
NASDAQ	11,993.00	1.33%	-2.05%	-11.39%	-12.09%
Европ	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
GB100	7,390.00	1.19%	-0.38%	-3.12%	5.30%
DE40	13,982.00	0.72%	-0.33%	-3.59%	-9.43%
FR40	6,285.00	0.20%	-1.22%	-6.40%	-1.58%
IT40	24,095.00	0.12%	0.26%	-0.76%	-3.20%
ES35	8,485.00	0.93%	1.76%	-3.74%	-3.20%
Ази	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
JP225	27,007.00	0.96%	1.68%	1.51%	-4.84%
SHANGHAI	3,146.00	0.00%	2.37%	7.44%	-10.03%
CSI 300	4,078.00	0.00%	3.06%	6.89%	-20.91%
SHANGHAI 50	2,808.00	0.00%	2.17%	0.37%	-19.36%
CH50	13,808.62	2.47%	1.75%	0.97%	-22.29%
SENSEX	54,326.00	2.91%	2.90%	-6.19%	7.49%
Эрчим хүч	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
Газрын тос (Crude Oil)	111.00	0.63%	-0.69%	13.70%	68.82%
Газрын тос (Brent)	113.38	0.79%	-0.69%	11.05%	65.72%
Байгалийн хий	8.07	-0.07%	1.52%	21.11%	179.87%
Шатахуун	3.85	0.33%	-4.27%	19.57%	81.85%
Нүүрс	417.25	1.25%	6.17%	26.02%	313.12%
Түүхий эд	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
Алт	1,851.69	0.33%	1.57%	-2.38%	-1.52%
Мөнгө	21.90	0.69%	1.43%	-7.19%	-21.20%
Зэс	4.31	0.75%	2.72%	-3.11%	-5.09%
Бонд /10 жил/	Өгөөж	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
АНУ	2.82	0.0288	-0.07%	0.00%	1.21%
Англи	1.87	0.0030	0.13%	-0.14%	1.04%
Швейцар	0.72	0.0180	-0.06%	-0.19%	0.71%
Испани	2.10	0.0160	0.09%	0.27%	1.55%
Португали	2.17	0.0390	0.10%	0.23%	1.61%

Эх сурвалж: Trading economics

Хөрөнгийн зах зээл ойрын хугацаанд сэргэх үү?

Өнгөрсөн Лхагва гарагт S&P 500 индекс 2020 оны 6 сараас хойш нэг өдрийн хамгийн хүчтэй уналт үзүүлсэн. Хөрөнгийн зах зээл 49 хоног тасралтгүй уналттай байгаа бөгөөд S&P 500 индекс он гарснаас хойш 18% унаад байна. Edwardjones-ийн шинжээчдийн үзэж байгаагаар ирэх 12 сард эдийн засгийн хямрал болохгүй гэж харж байгаа ч хөрөнгийн зах зээл U-хэлбэртэй сэргэлт үзүүлэх магадлал өндөр гэж төсөөлжээ.

Хөрөнгийн зах зээлийн уналтын гол 2 шалтгаан нь хямралын айдас болон компаниудын ашгийн маржин буурах эрсдэлээс бүрдэж байна

Өнгөрсөн 7 хоногт Walmart болон Target зэрэг том худалдааны бизнесүүдийн санхүүгийн тайлан таагүй гарсантай холбоотойгоор хөрөнгийн зах зээлд ихээхэн уналт үзүүлсэн. Уг хоёр компанийн гүйцэтгэл шинжээчдийн таамгаас доогуур гарсантай холбоотой байв. Ашигт ажиллагаа тааруухан гарсны шалтгаан нь тээвэр, шатахууны үнэ өссөнөөр өртөг нэмэгдсэнтэй холбоотой юм.



Хэдий дээрх компаниудын гүйцэтгэл таамгаас муу гарсан ч худалдан авалт тогтвортой байгаа нь АНУ-ын өрхийн худалдан авалтын чадвар сайн байгааг илтгэж байна. Жишээлбэл, Target-аар үйлчлүүлсэн иргэдийн тоо оны эхний улиралд 4%-иар нэмэгдсэн. Гол асуудал нь эрэлтээс илүү нийлүүлэлттэй холбоотой.

Шинжээчид худалдан авагчдын эрэлт оргил цэгтээ хүрсэн тул одоо буурч магадгүй гэж үзэж байгаа бол Target-ын гүйцэтгэх захирал энэ 5 сард дэлгүүрээр үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдэх боломжтой талаар онцолжээ. Үүний шалтгаан нь оны эцсийн хагаст нийлүүлэлтийн гинжин хэлхээ сайжирч, бараа материал илүү элбэг болохтой холбож тайлбарлав.

Эх сурвалж: www.edwardjones.com

Эдийн засгийн хямрал болно гэсэн таамаглал хараахан биелээгүй байна

Компаниудын оны эхний улирлын байдлаар ашиг буурах хандлагатай байгаа нь цаашдын өсөлтөд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг нэмэгдүүлж байна. Инфляц, бодлогын хүү өсөхөөс гадна нийлүүлэлтийн удаашралаас үүдэн эдийн засгийн хямрал болох вий гэсэн айдас газар авч эхэлсэн. Шинжээчдээс авсан санал асуулгаар 75% нь эдийн засгийн хямрал болно гэж хариулжээ.

Харин Edwardjones-ийн зүгээс АНУ-д ойрын 12 сард хямрал болохгүй болов уу гэж үзэж байна. Тэдний өнцгөөс АНУ-ын өрхийн худалдан авалт, ажилгүйдлийн түвшин, компаниудын ашигт ажиллагаа зэрэг эдийн засгийн үзүүлэлтүүд харьцангуй сайн байгаа гэжээ. 4-р сарын өрхийн худалдан авалт болон үйлдвэрлэлийн түвшин таамагласнаас илүү гарсан нь эдийн засаг тогтвортой байгаагийн шинж юм.

Дээрх хүчин зүйлсийг харгалзан бидний одоо туулж байгаа хөрөнгийн зах зээлийн уналт нь эдийн засгийн хямралаас үүдэлтэй гэж харахгүй байна. Түүхээс харахад, 1970 оноос хойш хөрөнгийн зах зээл ёроол ханш хүртлээ унаснаас хойш дунджаар 17% өссөн статистиктай. Хэдий ёроол ханшийг таамаглахад хүндрэлтэй ч хөрөнгийн зах зээл өнөөгийн байдлаар ойролцоогоор 25%-иар унахаас гадна, олон нийтэд хямрал болно гэсэн айдас ихсэж байгаа нь хөрөнгийн зах зээл магадгүй ёроолдоо хүрснийг илтэж байж болох юм.

Хөрөнгийн зах зээл ойрын хугацаанд өсөх боломжтой юу? Зарим шинжээчдийн үзэж байгаагаар бид U-хэлбэртэй сэргэлтийг харж магадгүй гэжээ

Хэрвээ энэ удаагийн хөрөнгийн зах зээлийн уналт, хямралаас үүссэн баавгай зах зээл биш бол хөрөнгө оруулагчид “одоогоос авч эхлэх нь зөв үү?” гэж асууж байгаа байх. Сүүлийн 5 жилд уналт болгонд авах арга барил боломжийн өгөөж өгч байсан. Харин энэ удаа өмнөх шиг V-хэлбэртэй биш, илүү U-хэлбэртэй цаг хугацааны хувьд удаан сэргэлт үзүүлэх болов уу гэж харж байна.

Эх сурвалж: www.edwardjones.com

S&P 500 индексийн сэргэлт



2018 болон 2020 онд хөрөнгийн зах зээл ихээхэн унах үед нэг зүйл давтагдсан. Энэ нь Холбооны Нөөцийн Сан бодлогын хүүг түүхэн доод хэмжээнд хүргэснээр хөрөнгийн зах зээл богино хугацаанд хүчтэй сэргэсэн. Энэ удаагийн уналтаар ХНС инфляцын түвшинг хяналтад авахаар хатуу мөнгөний бодлого баримталж байгаа билээ. Иймд, инфляцын түвшин зорилтод түвшинд хүрэх хүртэл хөрөнгийн зах зээлд сэргэлт тийм ч хурдан болохгүй болов уу.

Disney-ийн хувьцааг авах цаг болсон уу?

Disney-ийн хувьцаа сүүлийн нэг 1 жилийн хугацаанд 50%-иар унаад байгаа бөгөөд энэ нь авах боломж байж магадгүй. Тус компани өнгөрсөн 7 хоногт 2022 оны 2-р улирлын тайлангаа танилцуулсан ба борлуулалт болон ашгийн хувьд шинжээчдийн таамгаас доогуур гүйцэтгэлтэй байсан юм. Компанийн гүйцэтгэх захирал Боб Чапек энэхүү тааруу мэдээ үл ойшоон дотоодын паркийн салбар болон streaming үйлчилгээний өсөлтийг онцолсон юм. Жишээлбэл, Disney+ хэрэглэгчдийн тоо энэ улиралд 7.9 саяар нэмэгдсэнээр нийт streaming үйлчилгээний хэрэглэгчдийн тоо 205 саяд хүрчээ.

Хүчтэй өсөж буй streaming-ийн үзүүлэлт

Хувьцааны ханш 52 долоон хоногийн доод түвшинд хүрсэн нь худалдан авах байр суурийг дэмжиж өгч байна. Disney+ хэрэглэгчдийн тоо 7.9 саяар өсөж 137.7 саяд хүрсэн нь таамаглаж байсан 134.4 саяыг давж биелүүлсэн. Disney-ийн бусад streaming үйлчилгээнүүдийн нэг болох ESPN+ 22.3 сая хэрэглэгчтэй болсон нь таамаглаж байсан 22.5 саяас илүү байсан бол Hulu-гийн хэрэглэгчдийн тоо 45.6 саяд хүрсэн нь таамагласнаас 1 саяар бага байв.

Эх сурвалж: www.edwardjones.com

Hulu Plus Live TV-ийн хэрэглэгчдийн тоо 4.1 саяд хүрсэн нь 4.4 саяын таамгаас бага байж. **Ингээд Disney-гийн нийт streaming үйлчилгээг ашигладаг хэрэглэгчдийн тоо 205 саяд хүрч байгаа нь Netflix-ийн 221 сая хэрэглэгчдийн тоонд ихээхэн дөхсөн байна.** Netflix зөвхөн streaming салбарт үйл ажиллагаа явуулж байгаа бол **Disney нэмээд олон улсад паркууд ажиллуулдаг нь давуу тал болж байгаа ба паркийн салбараас олох орлого 6.7 тэрбум доллароор хэмжигдэж байна.** Disney-ийн гүйцэтгэх захирал нь хүмүүс паркаар үйлчлүүлэх эрэлт хүчтэй өсөж байгаа ба паркаар үйлчлүүлэх нэг хүнд ногдох зарцуулалтын хэмжээ 2019 онтой харьцуулахад 40%-иар өссөн талаар онцолсон юм.

Борлуулалтын гүйцэтгэл төлөвлөснөөс бага байсан тул хувьцааны ханш огцом унаж 100 доллар болсон. **100 долларын ханш нь техник шинжилгээний үүднээс чухал түвшин юм.** Яагаад гэвэл ханш сүүлийн 6 жил энэхүү түвшинд хэд хэдэн удаа дэмжих болон эсэргүүцлийн шулуунтай учирч байсан тул хөрөнгө оруулагчдын хувьд одоо л хувьцаанаас авах эсвэл зарахаа шийдэх болоод байна.

Disney ханш [DIS]



Bank of America-ийн шинжээч Disney-ийн хувьцааг “авах” санал өгсөн ч зорилтот ханшаа 191 доллароос 140 доллар болгож бууруулсан. Гэсэн хэдий ч одоогийн 100 долларын ханшаас 40% өсөх төлөвтэй байгаа юм. Тус шинжээч авах саналтай байгаагийн шалтгаан нь Disney-ийн паркийн үйл ажиллагаа болон streaming үйлчилгээг цаашид өснө гэж харж байгаатай холбоотой байна. **Citi** банкны шинжээч мөн худалдан “авах” саналтай байгаа ба зорилтот ханшийг 200 доллароор төсөөлжээ. Энэ нь одоогийн ханшаас бараг 100% өсөх төлөв юм.

Өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдал болон хөрөнгийн зах зээл хүндхэн төсөөлөлтэй байгаа ч Disney-ийн одоогийн байгаа эрсдэл-өгөөжийг тооцож харахад урт хугацаандаа авч хадгалахад боломжийн харагдаж байна.

Эх сурвалж: Investing.com



Tsogbadrah.n@ardsecurities.com



Утас: 9988 1656